



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Зүүнбүрэн сумын Цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2024/217/НА-СТА-ТШЗ

| | |
|---|--|
| Цахим хуудас: www.selenge@audit.gov.mn Сүхбаатар сум 2024 он | Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 70363040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 70363036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn Аудитыг гүйцэтгэсэн: Их наяд аудит ХХК Захирал: Х.Ариунзул Утас: 99077062 Цахим хаяг: ikhnayadaudit@gmail.com |
|---|--|

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

| | |
|---|-----------|
| 1. АУДИТЫН ДҮГНЭЛТ | 2 |
| 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ..... | 4 |
| 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА..... | 10 |
| 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа | 10 |
| 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин | 10 |
| 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал | 11 |
| 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд..... | 12 |
| 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв..... | 13 |
| 4. АУДИТЫН ТАЙЛАН | 14 |
| 4.1 Ерөнхий зүйл | 14 |
| 4.2 Материаллаг байдал..... | 15 |
| 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт | 15 |
| 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал | 15 |
| 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт..... | 16 |
| 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал | 16 |
| 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ | 17 |
| 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ..... | 18 |

Товчилсон үгийн жагсаалт

| | |
|--------|--|
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| БШУС | Боловсрол, шинжлэх ухааны сайд |
| БШУЯ | Боловсрол, шинжлэх ухааны яам |
| БЕГ | Боловсролын ерөнхий газар |
| БШУГ | Боловсрол, шинжлэх ухааны газар |
| НБББББ | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг |
| НДШ | Нийгмийн даатгалын шимтгэл |
| МУЕА | Монгол улсын ерөнхий аудитор |
| ХХК | Хязгаарлагдмал хариуцлагатай компани |



СУМЫН 1 ДҮГЭЭР ЦЭЦЭРЛЭГИЙН
СЭЛЭНГЭ АЙМГИЙН ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗҮҮНБҮРЭН
ЭРХЛЭГЧ Х.ӨЛЗИЙСАЙХАН ТАНАА

2024.02.23 № СЭА-2024/217/МН-СТН-ТШЗ
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Зүүнбүрэн сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сэлэнгэ аймгийн Зүүнбүрэн сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Зүүнбүрэн сумын 1 дүгээр цэцэрлэг нь Боловсролын Ерөнхий газрын даргын 2023 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн А/324 дүгээр тушаалаар сургалтын байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнгээр 5 дугаар түвшинд үнэлэгдсэн байна.

Аудитын гол асуудал

Нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд мөрдөж байгаа Боловсрол, Шинжлэх Ухааны сайдын 2021 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн А/22 дугаар тушаалаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг” нь гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжиж байгаа байгууллагын онцлогт тохироогүй, үр дүнд

суурилсан төсөвлөлт, санхүүжилт, хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний бүртгэлийн талаар нарийн тусгаагүй байна.

Байгууллагын төсөв, санхүүжилтийг зардлын эдийн засгийн ангиллаар нь бус “бараа үйлчилгээний бусад зардал” гэсэн ангиллаар бөөнд нь тусган, төлөвлөж, баталж байгаа нь төсвийг зардлын бүлэг, зүйлээр төлөвлөж, зарцуулах, зарцуулалтад хяналт тавих зарчмыг алдагдуулж байна.

Бусад асуудлын хэсэг

Тус байгууллага нь тайлант оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 9 зорилтын хүрээнд 20 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 82.4 хувийн гүйцэтгэлтэй үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Балансын зүйл | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|------------|---------------------------------------|-----------------------|-----------------------|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 44,501,910.93 | 164,877,443.85 |
| 31 | Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө | 18,922,706.02 | 129,420,349.72 |
| 311 | Кассанд байгаа | | |
| 312 | Банканд байгаа | 18,922,706.02 | 129,420,349.72 |
| 33 | АВЛАГА | - | 570,052.22 |
| 33200 | Төлбөртэй үйлчилгээний авлага | | 570,052.22 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 25,579,204.91 | 34,887,041.91 |
| 351 | Түүхий эд материал | - | |
| 354 | Хангамжийн материал | 25,579,204.91 | 34,887,041.91 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 429,450.00 | 924,287.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 12,674,999.91 | 18,565,999.91 |
| 35450 | Барилгын засварын материал | | 2,876,000.00 |
| 35460 | Хүнсний материал | | 46,000.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 12,474,755.00 | 12,474,755.00 |
| 356 | Мал амьтад | - | - |
| 36 | НӨӨЦИЙН БАРАА | - | - |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 717,919,003.06 | 738,065,843.16 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 717,919,003.06 | 738,065,843.16 |
| 392 | Биет хөрөнгийн дүн | 708,440,336.34 | 728,670,509.72 |
| 39201 | Барилга байгууламж | 709,136,301.42 | 719,586,305.14 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (61,044,653.64) | (78,023,064.84) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж | 44,482,848.00 | 81,907,248.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (14,298,027.92) | (27,124,430.80) |
| 39207 | Тавилга, эд хогшил | 54,775,102.86 | 64,691,102.86 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (35,124,316.22) | (41,194,927.80) |
| 39209 | Зам, гүүрийн байгууламж | 1,084,000.00 | 1,084,000.00 |
| 39210 | Хуримтлагдсан элэгдэл | (361,333.44) | (722,666.88) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 13,234,713.00 | 13,234,713.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (3,970,413.72) | (5,293,884.96) |
| 39217 | Ном | 526,116.00 | 526,116.00 |
| 393 | Биет бус хөрөнгийн дүн | 9,478,666.72 | 9,395,333.44 |
| 39301 | Программ хангамж | 250,000.00 | 250,000.00 |
| 39302 | Хасагдуулга | (83,333.28) | (166,666.56) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 9,312,000.00 | 9,312,000.00 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН | 762,420,913.99 | 902,943,287.01 |
| 4 | НИЙТ ӨР ТӨЛБӨР | - | 1,634,150.00 |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | - | 1,634,150.00 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 762,420,913.99 | 901,309,137.01 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 762,420,913.99 | 901,504,417.01 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал | 202,588,074.46 | 202,588,074.46 |
| 51101 | Өмч: -төрийн | 202,588,074.46 | 202,588,074.46 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | 72,320,596.31 | 211,208,819.33 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 52,858,293.64 | 101,570,453.03 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 19,462,302.67 | 109,638,366.30 |
| 51300 | Дахин үнэлгээний зөрүү | 487,512,243.22 | 487,512,243.22 |
| 6 | ӨР ТӨЛБӨР БА ЭЗ/ӨМЧИЙН ДҮН | 762,420,913.99 | 902,943,287.01 |

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|-------------|--|-------------------------|-----------------------|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН | 1,326,661,364.32 | 736,202,611.80 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 783,109,964.32 | 58,540,400.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 783,109,964.32 | 58,540,400.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 1,882,000.00 | - |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,022,000.00 | - |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 860,000.00 | - |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | 734,196,401.51 | 58,540,400.00 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал | 47,031,562.81 | |
| 13 | ТУСЛАМЖ САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 543,551,400.00 | 777,662,211.80 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 474,098,600.00 | 724,306,900.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 474,098,600.00 | 724,306,900.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | - | - |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | - | - |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | - | - |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 69,452,800.00 | 53,355,311.80 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 69,452,800.00 | 53,355,311.80 |
| 2 | Үйл ажиллагааны зардал | 564,240,450.33 | 697,314,388.78 |
| 21 | Урсгал зардал | 564,240,450.33 | 697,314,388.78 |
| 210 | Бараа, үйлчилгээний зардал | 558,455,064.92 | 697,314,388.78 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал | 346,551,372.80 | 454,035,039.91 |
| 210101 | Үндсэн цалин | 271,283,514.38 | 339,727,439.11 |
| 210102 | Нэмэгдэл цалин | 70,461,534.57 | 101,105,952.80 |
| 210104 | Урамшуулал | 4,806,323.85 | 13,201,648.00 |
| 2102 | Нийгмийн даатгалын шимтгэл | 43,458,258.81 | 57,735,437.17 |
| 210201 | Тэтгэврийн даатгалын | 29,719,628.57 | 39,735,832.24 |
| 210202 | тэтгэмжийн даатгалын | 3,496,391.09 | 4,674,803.86 |
| 210203 | ҮОМШӨ-ий даатгалын | 2,773,632.72 | 3,811,088.15 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгалын | 671,512.82 | 847,690.81 |
| 210205 | ЭМ-ийн даатгалын | 6,797,093.61 | 8,666,022.11 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 45,203,976.96 | 49,885,311.80 |
| 210301 | Гэрэл цахилгааны зардал | 7,137,336.96 | 9,354,530.41 |
| 210302 | Түлш, халаалтын зардал | 36,962,040.00 | 39,426,181.39 |
| 210303 | Цэвэр бохир усны зардал | 1,104,600.00 | 1,104,600.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 23,615,058.90 | - |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 23,615,058.90 | - |
| 2105 | Нормативт зардал | 66,354,700.00 | 77,672,110.00 |
| 210502 | Хоол, хүнс | 66,354,700.00 | 77,672,110.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 1,996,100.00 | 594,000.00 |
| 210604 | Урсгал засварын зардал | 1,996,100.00 | 594,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажлын хөлс | 370,700.00 | 1,174,800.00 |
| 210806 | Мэдээлэл технологийн үйлчилгээ | 370,700.00 | 1,174,800.00 |
| 2109 | Бараа, үйлчилгээний бусад зардал | 30,904,897.45 | 56,217,689.90 |

| | | | |
|-------------|---|-----------------------|-----------------------|
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 9,567,499.00 | 14,360,780.00 |
| 210902 | Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал | 4,200,000.00 | 3,463,350.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 17,137,398.45 | 38,393,559.90 |
| 213 | Урсгал шилжүүлэг | 5,785,385.41 | - |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 5,785,385.41 | - |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 5,785,385.41 | - |
| 2135 | Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг | - | - |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | - |
| 3 | Үйл ажиллагааны үр дүн | 762,420,913.99 | 138,888,223.02 |
| 225 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | - | 29,249,856.72 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | - | 29,249,856.72 |
| 4 | Үйл ажиллагааны бус үр дүн | - | (29,249,856.72) |
| 5 | Үйл ажиллагааны нийт үр дүн | 762,420,913.99 | 109,638,366.30 |

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|-------------|--|-----------------------|-----------------------|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН | 544,573,400.00 | 777,662,211.80 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 1,022,000.00 | - |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 1,022,000.00 | - |
| 120004 | Төсөвт байгууллагын өөрийн орлого | 1,022,000.00 | - |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,022,000.00 | - |
| 13 | ТУСЛАМЖ САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 543,551,400.00 | 777,662,211.80 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 474,098,600.00 | 724,306,900.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 474,098,600.00 | 724,306,900.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | | - |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | - | - |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | - |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 69,452,800.00 | 53,355,311.80 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 69,452,800.00 | 53,355,311.80 |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 525,650,693.98 | 667,164,568.10 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 525,650,693.98 | 667,164,568.10 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 519,865,308.57 | 667,164,568.10 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал | 346,551,372.80 | 454,605,092.08 |
| 210101 | Үндсэн цалин | 271,283,514.38 | 337,521,107.83 |
| 210102 | Нэмэгдэл | 70,461,534.57 | 104,220,251.06 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | | |
| 210104 | Урамшуулал | 4,806,323.85 | 12,863,733.19 |
| 2102 | Ажил олгогчийн нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 43,458,258.81 | 57,735,437.22 |
| 210201 | Тэтгэврийн даатгалын | 29,719,628.57 | 39,735,832.29 |
| 210202 | Тэтгэмжийн даатгалын | 3,496,391.09 | 4,674,803.86 |

| | | | |
|-------------|---|----------------------|-----------------------|
| 210203 | ҮОМШӨ-ий даатгалын | 2,773,632.72 | 3,811,088.15 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгалын | 671,512.82 | 847,690.81 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгалын | 6,797,093.61 | 8,666,022.11 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 45,203,976.96 | 49,885,311.80 |
| 210301 | Гэрэл цахилгааны зардал | 7,137,336.96 | 9,354,530.41 |
| 210302 | Түлш, халаалтын зардал | 36,962,040.00 | 39,426,181.39 |
| 210303 | Цэвэр бохир усны зардал | 1,104,600.00 | 1,104,600.00 |
| 2105 | Нормативт зардал | 66,234,300.00 | 77,718,110.00 |
| 210501 | Эм | - | - |
| 210502 | Хоол, хүнс | 66,234,300.00 | 77,718,110.00 |
| 210503 | Нормын хувцас | - | - |
| 2106 | Эд хогшил урсгал засвар | 1,996,100.00 | 3,470,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 1,996,100.00 | 3,470,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажлын, үйлчилгээний төлбөр, хураамж | 962,000.00 | 1,174,800.00 |
| 210806 | Мэдээлэл технологийн үйлчилгээ | 962,000.00 | 1,174,800.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 15,459,300.00 | 22,575,817.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 11,259,300.00 | 18,617,630.00 |
| 210902 | Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх | 4,200,000.00 | 3,958,187.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 5,785,385.41 | - |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | - | - |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 5,785,385.41 | - |
| 3 | Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ | 18,922,706.02 | 110,497,643.70 |
| | Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ | | |
| 4 | Хөрөнгө оруулалтын мөнгөн орлогын дүн | - | - |
| 5 | Хөрөнгө оруулалтын мөнгөн зарлагын дүн | - | - |
| 22 | Хөрөнгийн зардал | - | - |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | - | - |
| 223001 | Бусад хөрөнгө | - | - |
| 6 | Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ | - | - |
| 7 | Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ | - | - |
| 8 | Нийт цэвэр мөнгөн гүйлгээ | 18,922,706.02 | 110,497,643.70 |
| 9 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | 18,922,706.02 |
| 10 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 18,922,706.02 | 129,420,349.72 |

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

| Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан үр дүн | Засгийн газрын хувь оролцооны үр дүн |
|---|---------------------------------|-----------------------|-----------------------|--------------------------------------|
| А | 1 | 2 | 3 | 4 |
| 2021 оны 12 дугаар сарын 31-нээрх үлдэгдэл | 202,588,074.46 | 487,512,243.22 | 52,858,293.64 | 742,958,611.32 |
| НББ-ийн бодлогын өөрчлөлт | | | (742,958,611.32) | (742,958,611.32) |
| Дахин илэрхийлсэн үлдэгдэл | | | | - |
| ҮХ-ийн өсөлт, бууралт | - | - | - | - |
| ҮХ-ийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | - | - | - | - |
| Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | - | - | - | - |
| Тайлант үеийн үр дүн | - | - | 762,420,913.99 | 762,420,913.99 |
| 2022 оны 12 дугаар сарын 31-нээрх үлдэгдэл | 202,588,074.46 | 487,512,243.22 | 72,320,596.31 | 762,420,913.99 |
| 2023 оны 12 дугаар сарын 31-нээрх үлдэгдэл | 202,588,074.46 | 487,512,243.22 | 72,320,596.31 | 762,420,913.99 |
| НББ-ийн бодлогын өөрчлөлт | - | - | 29,249,856.72 | 29,249,856.72 |
| Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 202,588,074.46 | 487,512,243.22 | 101,570,453.03 | 791,670,770.71 |
| ҮХ-ийн дахин үнэлгээний бууралт | - | - | - | - |
| Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | - | - | - | - |
| Тайлант үеийн үр дүн | - | - | 109,638,366.30 | 109,638,366.30 |
| 2023 оны 12 дугаар сарын 31-нээрх үлдэгдэл | 202,588,074.46 | 487,512,243.22 | 211,208,819.33 | 901,309,137.01 |

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

| Д/Д | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|--------|--|----------------|----------------|----------------|------|
| 1 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | - | | |
| 2 | Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн | 809,583,700.00 | 667,164,568.10 | 142,419,131.90 | 82.4 |
| 21 | Урсгал зардлын дүн | 809,583,700.00 | 667,164,568.10 | 142,419,131.90 | 82.4 |
| 210 | Бараа үйлчилгээний зардал | 809,583,700.00 | 667,164,568.10 | 142,419,131.90 | 82.4 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 556,132,100.00 | 454,605,092.08 | 101,527,007.92 | 81.7 |
| 210101 | Үндсэн цалин | 373,369,200.00 | 337,521,107.83 | 35,848,092.17 | 90.4 |
| 210102 | Нэмэгдэл | 170,585,500.00 | 104,220,251.06 | 66,365,248.94 | 61.1 |

| | | | | | |
|--------|--|----------------|----------------|---------------|-------|
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | - | - | - | |
| 210104 | Урамшуулал | 12,177,400.00 | 12,863,733.19 | (686,333.19) | 105.6 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | - | - | | |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 74,101,500.00 | 57,735,437.22 | 16,366,062.78 | 77.9 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 50,389,400.00 | 39,735,832.29 | 10,653,567.71 | 78.9 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 5,928,300.00 | 4,674,803.86 | 1,253,496.14 | 78.9 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 4,742,100.00 | 3,811,088.15 | 931,011.85 | 80.4 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,185,300.00 | 847,690.81 | 337,609.19 | 71.5 |
| 210205 | ЭМД-ын хураамж+В21 | 11,856,400.00 | 8,666,022.11 | 3,190,377.89 | 73.1 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 62,884,100.00 | 49,885,311.80 | 12,998,788.20 | 79.3 |
| 210301 | Гэрэл цахилгааны зардал | 11,921,300.00 | 9,354,530.41 | 2,566,769.59 | 78.5 |
| 210302 | Түлш, халаалтын зардал | 49,858,200.00 | 39,426,181.39 | 10,432,018.61 | 79.1 |
| 210303 | Цэвэр бохир усны зардал | 1,104,600.00 | 1,104,600.00 | | 100.0 |
| 2105 | Нормативт зардал | 89,041,400.00 | 77,718,110.00 | 11,232,290.00 | 87.3 |
| 210501 | Эм | - | - | | |
| 210502 | Хоол хүнс | 89,041,400.00 | 77,718,110.00 | 11,323,290.00 | 87.3 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 3,470,000.00 | 3,470,000.00 | - | 100.0 |
| 210604 | Урсгал засвар | 3,470,000.00 | 3,470,000.00 | - | 100.0 |
| 2107 | Томилолт, зочны зардал | - | - | - | - |
| 210702 | Дотоод томилолт | - | - | - | - |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр | 1,319,600.00 | 1,174,800.00 | 144,800.00 | 89.0 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр | - | - | - | - |
| 210806 | Мэдээлэл технологийн үйлчилгээ | 1,319,600.00 | 1,174,800.00 | 144,800.00 | 89.0 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 22,635,000.00 | 22,575,817.00 | 59,183.00 | 99.7 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 18,676,300.00 | 18,617,630.00 | 58,670.00 | 99.7 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 3,958,700.00 | 3,958,187.00 | 513.00 | 99.9 |
| 1 | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 809,583,700.00 | 777,662,211.80 | 31,921,488.20 | 96.1 |
| 131 | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 743,229,600.00 | 724,306,900.00 | 18,922,700.00 | 97.5 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 743,229,600.00 | 724,306,900.00 | 18,922,700.00 | 97.5 |

| | | | | | |
|--------|---|---------------|----------------|------------------|------|
| 132 | ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 66,354,100.00 | 53,355,311.80 | 12,998,788.20 | 80.4 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 66,354,100.00 | 53,355,311.80 | 12,998,788.20 | 80.4 |
| 120 | Төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогоос | - | - | - | - |
| 124 | БУСАД ЭХ ҮҮСВЭР | - | - | - | - |
| 31 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | 18,922,706.02 | (18,922,706.02) | |
| 31 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | 129,420,349.72 | (129,420,349.72) | |

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сэлэнгэ аймгийн Зүүнбүрэн сумын цэцэрлэг нь “Хүүхэд бүрийн сурч төлөвших нөхцөлийг бүрдүүлж, эрүүл аюулгүй орчин нөхцөлийг бий болгон, багш мэргэжлээрээ тасралтгүй хөгжих боломжийг бүрдүүлэнэ.” гэсэн эрхэм зорилгын хүрээнд үйл ажиллагаагаа явуулсан байна.

Үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Хүүхэд бүрийн сурч хөгжих, төлөвших, эрүүл аюулгүй орчин нөхцөлийг бүрдүүлэхийн тулд багш, эцэг эх хамтран ажиллаж, үр дүнг тооцох,
- Сум орон нутгийн 5 настай хүүхэд бүрийг сургуулийн өмнөх боловсролд тэгш хамруулан сургуульд суралцах бэлтгэлийг хангах
- Хүүхдийг шим тэжээллэг хоол хүнсээр хангах зохистой дадал хэвшилд сургах, байгууллагын хоол хоол үйлдвэрлэл, үйлчилгээний чанарыг сайжруулах
- Багш бүр ажлын байран дээрээ тасралтгүй хөгжих боломжит хэлбэрүүдийг ашиглан заах арга зүй, ур чадвараа хөгжүүлэх
- Сургалтын орчныг сайжруулах, аюулгүй байдлын стандарт, шаардлагад нийцүүлэх, өндөржүүлсэн бэлэн байдал болон эрсдэлээс урьдчилан сэргийлэх ажлыг үр дүнтэй зохион байгуулж ажиллах
- Хүүхдийн хүмүүжил, хөгжил, хамгааллын асуудлаар эцэг эх, асран хамгаалагчтай гурвалсан гэрээ байгуулж тэдний үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх
- Багш, туслах багш, ажилтан бүр нь ажлын байрандаа сахилга хариуцлагыг чандлан сахиж, ёс зүйн хэм хэмжээг баримтлан бүтээлчээр ажиллах

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг дараах хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,
- Боловсролын ерөнхий хууль 2023 оны 07 дугаар сарын 07-нд батлагдсан,
- Хөдөлмөрийн тухай хуульд 2023 оны 07 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Төрийн хэмнэлтийн тухай хуульд 2023 оны 06 дугаар сарын 16, 07 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 241 дүгээр тогтоолоор төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон,
- БШУС-ын 2023 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн 1/2714 тоот албан бичгээр боловсролын байгууллагын төсвийн шинэчлэлийн хүрээнд: "Цэцэрлэгт шаардлагатай хүүхдийн тоглоом, наадгай, зөөлөн эдлэл ханган нийлүүлэх, худалдан авах ажиллагааг зохион байгуулах" чиглэлийг хүргүүлсэн гэх мэт.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналт, үйл ажиллагааны зохион байгуулалтын хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ.

Тайлант онд тус байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд БШУЯ-ны Хяналт, шинжилгээ үнэлгээний газрын Дотоод аудитын хэлтсээс хяналт, шалгалт хийгдээгүй боловч сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, шилэн дансны мэдээллээр дамжуулан дотоод хяналт, шалгалтыг хэрэгжүүлсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сэлэнгэ аймгийн Зүүнбүрэн сумын цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн, хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

Тус байгууллага нь Боловсрол, Шинжлэх Ухааны сайдын 2021 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн А/22 дугаар тушаалаар баталсан Боловсрол, Шинжлэх Ухааны салбарын төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа төсөвт байгууллагуудад мөрдөгдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн хэдий ч гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжиж байгаа байгууллагын онцлогт тохироогүй, үр дүнд суурилсан төсөвлөлт, санхүүжилт, хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний бүртгэлийн талаар нарийн тусгаагүй өөрөөр хэлбэл боловсролын салбарын онцлогт тохирохгүй байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Сэлэнгэ аймгийн Зүүнбүрэн сумын цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгө 902,943.3 мянган төгрөг болж өмнөх оноос 140,522.4 мянган төгрөгөөр буюу 18.4 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|------------------|------------------|------------------|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 18,922.7 | 129,420.3 | 110,497.6 |
| Авлага | - | 570.2 | 570.2 |
| Бараа материал | 25,579.2 | 34,887.0 | 9,307.8 |
| Үндсэн хөрөнгө | 717,919.0 | 738,065.8 | 20,146.8 |
| Нийт хөрөнгө | 762,420.9 | 902,943.3 | 140,522.4 |
| Өр төлбөр | - | 1,634.2 | 1,634.2 |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 762,420.9 | 901,309.1 | 138,888.2 |
| Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн | 762,420.9 | 902,943.3 | 140,522.4 |

/мянган төгрөгөөр/

Дээрх хүснэгтээс харахад дараах дансанд нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгийн данс 129,420.3 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байгаа нь Төсвийн тухай хуулийн 7.9-д заасны дагуу тайлант жилийн үйл ажиллагааны зардлын хэмнэлтийг төрийн сангийн харилцах дансанд үлдэгдлээр тайлагнасантай холбоотой байна.
- Бараа материалын дансны үлдэгдэл 34,887.0 мянган төгрөг болж 9,307.8 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд 98,917.6 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, 89,609.7 мянган төгрөгийн бараа материал зарцуулж, 34,887.0 мянган төгрөгийн материалын үлдэгдэлтэй тайлагнагдсан нь голлон нөлөөлсөн байна.
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 738,065.8 мянган төгрөг болж 20,146.8 мянган төгрөгөөр өссөн нь БШУЯ-аас үнэ төлбөргүй шилжүүлж авсан 58,540.4 мянган төгрөгийн хөрөнгө орлогодож авснаас шалтгаалсан байна.

- Богино хугацаат өр төлбөр данс нь 1,634.2 мянган төгрөгийн өр төлбөртэй тайлагнагдсан нь Интерворлд ХХК-д төлөх бичиг хэрэг, аж ахуйн материалын өглөгтэй холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 537,377.0 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 66,354.1 мянган төгрөг, нийт 603,731.1 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас улсын төсвийн санхүүжилтийг 205,852.6 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн тооцож улсын төсвөөс 722,366.1 мянган төгрөгөөр, орон нутгийн төсвөөс 66,354.1 мянган төгрөгөөр, урьд оны дансны үлдэгдлээс 20,863.5 мянган төгрөгийг төвлөрүүлэн нийт 809,583.7 мянган төгрөгийг зарцуулахаар баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 12 арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс 743,229.6 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 66,354.1 мянган төгрөг, нийт 809,583.7 мянган төгрөгийн эх үүсвэрийг урсгал үйл ажиллагаанд захиран зарцуулахаар төлөвлөгдсөн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 667,164.69 мянган төгрөг буюу 82.4 хувьтай байгаа нь цалин хөлс, нэмэгдэл урамшлын зардлыг 101,527.0 мянган төгрөгөөр, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 16,366.1 мянган төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 12,998.8 мянган төгрөгөөр, хоолны зардлыг 11,323.3 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг 144.8 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардал 59.2 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

| д/д | Хөтөлбөр | д/д | Арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | зөрүү | Биелэлт |
|-----|---|-----|---------------------------------------|------------|-----------|----------|---------|
| 1 | 71801 Сургуулийн өмнөх боловсрол | 1 | 81605- Эрүүл мэндийг дэмжих | 1,979.3 | 1,979.2 | 0.1 | 100.0 |
| | | 2 | 81801- Цэцэрлэгийн хүүхдийн хоол | 85,853.6 | 74,530.3 | 11,323.3 | 86.8 |
| | | 3 | 81816- Хүүхдэд ээлтэй сургалтын орчин | 3,641.0 | 3,641.0 | - | 100.0 |
| | | 4 | 81823- Боловсролын байгууллагын багш | 1,979.3 | 1,973.4 | 5.9 | 99.7 |

| | | | | | | |
|--|---|--|------------------|------------------|------------------|-------------|
| | | ажилчдын мэргэжил дээшлүүлэх | | | | |
| | 5 | 81832-Нүүдлийн бүлэгт хамруулах | 10,225.8 | 4,587.8 | 5,638.0 | 44.9 |
| | 6 | 81834- Боловсролын стандарт сургалт | 518,635.0 | 436,658.5 | 81,976.5 | 84.2 |
| | 7 | 81835- Сургалтын хэвийн үйл ажиллагаа | 120,915.6 | 90,439.0 | 30,476.6 | 74.8 |
| | 8 | 80111- Төрийн өмчийн байгууллагын тогтмол зардал | 66,354.1 | 53,355.3 | 12,998.8 | 80.4 |
| | | Нийт | 809,583.7 | 667,164.5 | 142,419.2 | 82.4 |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Зүүнбүрэн сумын цэцэрлэг нь 2023 онд төсвийн хөрөнгөөр хүүхдийн хоол хүнсний материал худалдан авахаар 89,041.4 мянган төгрөг төсөвлөсөн байна.

Тус цэцэрлэг нь тайлант онд худалдан авах ажиллагааны урилгыг tender.gov.mn цахим сайтад байршуулж, зохион байгуулсан байна. Бэлтгэн нийлүүлэгчийг сонгон шалгаруулах худалдан авах ажиллагааны шалгаруулалтад “Бринг торч” ХХК-тай гэрээ байгуулан худалдан авалтыг гүйцэтгэсэн байна. /

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сэлэнгэ аймгийн Зүүнбүрэн сумын цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу “Их наяд аудит” ХХК-ийн аудитор Х.Ариунтуяа гүйцэтгэж, хяналтыг захирал Х.Ариунзул, дараагийн шатны хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, газрын захирал, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Сэлэнгэ аймгийн Зүүнбүрэн сумын цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Их наяд аудит” ХХК-д 2024 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 03 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 564,240.4 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 5,642.4 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Зүүнбүрэн сумын цэцэрлэг нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Үйл ажиллагаатай холбоотой сурталчилгаа, баяр ёслолын арга хэмжээг зохион байгуулаагүй, төсвийн хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдаж аваагүй,
- Шаардлагагүй бараа материалыг их хэмжээгээр авч нөөцлөөгүй,
- Хэвлэл захиалгын төлбөр гаргалгүй ажилласан зэрэг төсвийн шууд захирагчтай хамааралтай заалтуудыг мөрдөж, батлагдсан төсвийн хүрээнд үйл ажиллагаа явуулсан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тус цэцэрлэг нь шилэн дансны нэгдсэн системд мэдээлбэл зохих 20 төрлийн 149 мэдээллээс 2 мэдээллийг байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Хуулийн дагуу мөнгөн гүйлгээний мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд ил тод, үнэн зөв, бүрэн байршуулж байх зөвлөмж өгсөн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тайлант онд бусад хууль, тогтоомжийн хэрэгжилтэд хамаарах алдаа, зөрчил илрээгүй.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын 2023 оны 10 дугаар сарын 26-ны 123 дугаар “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд 2023 оны санхүүгийн тайлангийн завсрын аудитаар 9,706.7 мянган төгрөгийн 3 алдаа илэрснээс жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар шалгахад алдааг залруулсан байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 11,572.6 мянган төгрөгийн зөрчил илэрснээс хоолны зардлын нормативыг хэтрүүлэн зарцуулсан зөрчилд 1 албан шаардлага, худалдан авалтын цахим төлбөрийн баримтыг бөөн дүнгээр баталгаажуулсан, санхүүгийн тайлангийн тайлбар тодруулга хийж байх зөрчилд 1 зөвлөмж тус тус өгөгдсөн байна.

Өмнөх оны аудитаар өгөгдсөн албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг нотлох баримттай тулган баталгаажуулахад 100 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|-----------------|------------------------|-----------------|----------|-----------------|--------------|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Төлбөрийн акт | | | | | |
| Албан шаардлага | 1 | 196.3 | 1 | 196.3 | 100.0 |
| Зөвлөмж | 1 | 11,376.3 | 1 | 11,376.3 | 100.0 |
| Нийт дүн | 2 | 11,572.6 | 2 | 11,572.6 | 100.0 |

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

1. Дээд шатны төсөв захирагчаас төсвийг зардлын эдийн засгийн ангиллаар нь бус “бараа үйлчилгээний бусад зардал” гэсэн ангиллаар бөөнд нь тусган, төлөвлөж, баталж байгаа нь төсвийг зардлын бүлэг, зүйлээр төлөвлөж, зарцуулах, зарцуулалтад хяналт тавих зарчмыг алдагдуулж байна.

Иймд төсвийг бодит гүйцэтгэлтэй нь уялдуулан зардлын бүлэг, зүйл бүрээр төлөвлөж, зарцуулан гүйцэтгэж байх шаардлагатай байна.

2. Цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан үндсэн хөрөнгийн тооллого хийж, биет тест хэрэгжүүлэх горимыг бүрэн хэрэгжүүлээгүй болно.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 9,706.7 мянган төгрөгийн алдаа 4 алдаа илэрснийг аудитын явцад залруулав. Үүнд:

1. Иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудаас цахим баримтгүй 5,405.5 мянган төгрөгийн худалдан авалтыг гүйцэтгэсэн.
2. Цалингийн зардал, түүнтэй холбоотой 3,526.8 мянган төгрөгийн ажил гүйлгээг журналд мөнгөн сууриар бүртгэж, тайлагнасан.
3. Журналд НДШ-ийн зардлыг 774.4 мянган төгрөгөөр зөрүүтэй тусгаж тайлагнасан.
4. Авлага, өр төлбөрийг журналд тусгахдаа харилцагчийг буруу сонгож илүү дутуу илэрхийлсэн байна.

Аудитаар нийт 1 зөрчил¹ илэрч, зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж хүргүүлээ.

5.1 Төлбөрийн акт

Шалгуур үзүүлэлтийг харгалзалгүйгээр хавсралтад дурдсан багш нарт тус бүр 20.0 хувиар тооцон, нийт 896.7 мянган төгрөгийн ур чадварын нэмэгдэл илүү олгосон зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 6.4.1 дэх "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Боловсрол шинжлэх ухааны сайд, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын 2021 оны 02 сарын 01-ний өдрийн А/35, А/102 дугаар хамтарсан "Шалгуур үзүүлэлт шинэчлэн батлах тухай" тушаалын 1 дүгээр хавсралтын 10 дахь "Энэхүү баримт бичгийн 4,5-д заасан шалгуур үзүүлэлтийн дагуу хийсэн үнэлгээнд 60.0 ба түүнээс дээш хувь үнэлэгдсэн багш, ажилтны ажлын үр дүн, манлайлал, мэргэжлийн хөгжлийн ахиц дэвшил, амжилтын түвшнийг харгалзан нэмэгдлийг дараах хувиар тогтооно" **"сум, дүүргийн түвшинд амжилт гаргасан 15%"** гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Илрүүлэлт: Зүүнбүрэн сумын сургуулийн үндсэн орон тоонд нягтлан бодогчоор ажиллаж буй Ц.Уянгыг тус цэцэрлэгт зэрэгцсэн хөдөлмөрийн гэрээгээр нягтлан бодогчоор ажиллуулан, цалинжуулж / үндсэн цалингийн 80.0 хувиар тооцож / байгаа нь дараах хуулиудыг тус тус зөрчиж байна. Үүнд:

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

- Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1 дэх "Төрийн албан хаагч дараах нийтлэг үүрэг хүлээнэ" 37.1.17: "Үндсэн ажлаасаа гадуур хуулиар зөвшөөрснөөс бусад ажил, үүрэг эрхлэхгүй байх",
- 38 дугаар зүйлийн 38.1 дэх "Төрийн албан хаагч дараах нийтлэг эрх эдэлнэ", 38.1.6: "Багшлах, эрдэм шинжилгээний ажил эрхлэх", 38.1.7: "Хууль тогтоомжоор хориглоогүй, албан тушаалын ашиг сонирхолд харшлахгүй арга хэлбэрээр хувийн аж ахуй эрхлэх...",
- Хөдөлмөрийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.3 дахь "Зэрэгцсэн хөдөлмөрийн гэрээтэй ажилтны нийт ажлын цаг энэ хуулийн 84.4 -т заасан ажлын цагийн дээд хязгаарт багтах ёстой бөгөөд үүнд ажилтан, үндсэн болон зэрэгцсэн ажил олгогч тус тус хяналт тавина", 84 дүгээр зүйлийн 84.4 дэх "Долоо хоногийн ажлын цагийн дээд хязгаар нь 56 цагаас илүүгүй байна. Өдөрт ажиллах илүү цагийн хязгаар нь 4 цагаас илүүгүй байна" зэрэг.

1.2 Өгсөн зөвлөмж: 2 байгууллагад зэрэгцээ хөдөлмөрөөр нягтлан бодогчийн албан тушаал эрхлүүлж буй зөрчлийг таслан зогсоож, зайлшгүй тохиолдолд цалинг өдрийн 4 цагаар бодож, 50.0 хувиас хэтрүүлэхгүй байх.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20.5² дахь заалтад тусгасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2024 оны 06 дугаар сарын 15 - ны өдрийн дотор тус тус төрийн аудитын байгууллагад ирүүлнэ үү

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

² Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

| Д/д | Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|-----|---|------------|----------------|-----------------------------------|-----|--------------------------|----------------|------------|----------------|--------------|-----|---------|-----|
| | | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Залруулсан | | Залруулаагүй | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Цахим баримтгүй худалдан авалт гүйцэтгэсэн | 1 | 5,405.5 | | | 1 | 5,405.5 | 1 | 5,405.5 | | | | |
| 2 | Цалингийн зардлыг журналд мөнгөн сууриар хөтөлж, бүртгэсэн | 1 | 3,526.8 | | | 1 | 3,526.8 | 1 | 3,526.8 | | | | |
| 3 | НДШ-ийн зардлыг журналд зөрүүтэй тайлагнасан | 1 | 774.4 | | | 1 | 774.4 | 1 | 774.4 | | | | |
| 4 | Авлага, өр төлбөрийг журналд тусгахдаа харилцагчийг буруу сонгож илүү дутуу илэрхийлсэн байна | 1 | | | | 1 | | 1 | | | | | |
| | Дүн | 4 | 9,706.7 | 1 | | 4 | 9,706.7 | 4 | 9,706.7 | | | | |

/мянган төгрөгөөр/

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

| Д/д | Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
|-----|--|-------------|-------|---------------|--------------|-----------------|-----|----------|-----|--------------------------------------|-----|---|-----|
| | | Нийт зөрчил | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Албан хаагчдад ур чадварын нэмэгдлийг илүү тооцож олгосон | 1 | 896.7 | 1 | 896.7 | | | | | | | | |
| 2 | Нягтлан бодогчийг зэрэгцээ хөдөлмөрийн гэрээгээр ажиллуулсан | 1 | - | | | | | 1 | - | | | | |
| | Дүн | 2 | | 1 | 896.7 | | | 1 | | | | | |

/мянган төгрөгөөр/

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Албан шаардлага | | Үүнээс | |
|---|-------------|-----|-----------------|-----|--------|----------------|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Зөвлөмж Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | 1 | | | | 1 | |
| Шилэн дансны цахим хуудсанд 2 мэдээллийг мэдээллээгүй. Дүн | 1 | | | | 1 | |
| Бусад хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | |
| Дүн | | | | | | |
| Нийт дүн | 1 | | | | 1 | |